

## Хувьцаа эзэмшигчдэд хүргэх захидал – 2023.06.22

---

### **Эрхэм хувьцаа эзэмшигчид ээ,**

Өнгөрсөн жил манай компанийн хувьд онцгой амжилттай байлаа. Бид Монгол Улсын баруун өмнөд хэсэгт орших Хөндий Эрдсийн Дүүрэгт (“ХЭД” буюу “Дүүрэг”) хайгуулын хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэхийн зэрэгцээ Баянхөндий (“БХ”) алтны төслийг (“Төсөл”) олборлолтын шат руу хөгжүүлэхээр Стратегийн түншлэлийн гэрээг үзэглэсэн. Бид энэхүү амжилтыг баг хамт олны шаргуу хөдөлмөр, хувьцаа эзэмшигчдийн дэмжлэгийн үр дүнд бий болгосон юм.

Ерөнхийлөн авч үзвэл Монгол Улсын уул уурхайн салбарын хувьд өнгөрсөн жил Оюутолгой зэс-алтны ордын далд уурхай ашиглалтад орсон ба энэхүү бүтээн байгуулалт нь дэлхий дахинд дөрөв дэх том зэсийн уурхай болохоор байна. Ингэснээр дэлхийн хоёр дахь том уул уурхайн компани Рио Тинто нь Туркойз Хилл Ресурсийг хувьчлах замаар Оюутолгойн эзэмшлийг нэгтгэж, төслийн нийт үнэлгээ нь ойролцоогоор 10 тэрбум ам.доллар болсон билээ.

Оюу Толгой оршдог Монгол Улсын зүүн өмнөд бүс болон манай Хөндий Эрдсийн Дүүрэг оршдог баруун өмнөд бүс нутаг нь хоорондоо ижил төстэй зүйлс олон. 1990 онд намайг Монголд анх ирэхэд Монгол Улсын зүүн өмнөд бүсэд хайгуул хязгаарлагдмал хийгдсэн, өнөөгийн баруун өмнөд бүстэй адил нөхцөл байдалтай байлаа. Эдгээр дүүргүүд нь томоохон өндөр агуулга бүхий алт, зэс, молибденийн ордуудыг агуулдаг геологийн хэтийн төлөв бүхий бүсүүд юм.

Эрдэнэ Ресурсийн хувьд түүх давтагдуулах боломж үүсэж байна. Бид геологи хайгуулын туршлагын хүрээнд өндөр агуулга бүхий алт, суурь металлын ордуудыг нээн илрүүлж, Монгол Улсын тэргүүлэгч групп компаниудын нэгтэй олборлолт, төсөл хөгжүүлэлтийн хүрээнд стратегийн түншлэл байгуулан ажиллаж байна. Бидний төвлөрч буй анхны төсөл нь бусад төслүүдийг хөгжүүлэх гол хөшүүрэг болно. Стратегийн түншлэлээр дамжуулан дэлхийн хамгийн том металл хэрэглэгчтэй зэрэгцээ бүс нутагт, Хөндий Эрдсийн Дүүрэгт томоохон дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хөгжүүлэх боломжтой.

Бид ирээдүйн хөгжлийн суурийг бий болгосон гэдэгтээ итгэлтэй байгаа бөгөөд Компанийн өсөлтийн талаар өндөр хүлээлттэй байна. Энэ захидлаар дамжуулан би бүх оролцогч талуудад үнэ цэнийг нэмэгдүүлэх 2023 оны төлөвлөгөө, урт хугацааны стратегийг тоймлон хүргэж байна.


## Стратегийн түншлэл – Монголын тэргүүлэгч хайгуулын компани болон тэргүүлэх олборлогчийн хоршил

2023 оны эхээр Компани нь Хөндий Эрдсийн Дүүрэг дэх өндөр агуулга бүхий алтны төслүүдийг хөгжүүлэх, бүтээн байгуулалтын шийдвэрт ойр Баянхөндий алтны ордыг олборлолтын шат руу ахиулах зорилгоор Монголиан Майнинг Корпорэйшн ("ММС")-тэй стратегийн түншлэл байгуулсан.

ММС нь өндөр чанар бүхий, гангийн үйлдвэрлэлд ашиглах нүүрс олборлон, экспортлогч, хувийн хэвшлийн хамгийн том төлөөлөл ба Монгол Улсын Өмнөговь аймагт байрлах Ухаа худаг ("УХ"), Баруун наран ("БН") уурхайд тус тус үйл ажиллагаа явуулдаг. ММС нь Эрдэнэ Ресурстэй түншлэн ажилласнаар бизнесийн цар хүрээ болон орлогын эх үүсвэрээ өргөжүүлэн, бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Тус компанийн хувьцаа Хонконгийн хөрөнгийн биржид (HKEx:975) нээлттэй арилжаалагддаг бөгөөд компанийн зах зээлийн үнэлгээ одоогоор 300 орчим сая ам.доллар байна.

Стратегийн түншлэлийн хүрээнд ММС нь Эрдэнэ Ресурсийн Монгол дахь охин компани болох Эрдэнэ Монгол ХХК ("ЭМ")-ийн 50%-тай тэнцэх хувьцааг, Эрдэнэ Ресурс нь ЭМ-ийн 50%-г тус тус эзэмшинэ. Эрдэнэ Ресурс нь эхний 400,000 унц алтны олборлолтоос давсан олборлолт болон Баянхөндий алтны төслийн хүрээнд 700 км<sup>2</sup> талбайд эзэмших тусгай зөвшөөрлүүдийн 5%-ийн борлуулалтын орлогын төлбөр ("Net smelter return" буюу "NSR") (цаашид "БОТ" гэх) авна. Тус борлуулалтын орлогын төлбөрийг хадгалснаар бид Хөндий Эрдсийн Дүүргийн урт хугацааны үнэ цэний 60%-г Эрдэнэ Ресурсийн хувьцаа эзэмшигчдэд ногдоно хэмээн тооцож байна. Түүнээс гадна, Эрдэнэ Ресурс нь Зуун Мод молибден-зэсийн орд болон хайгуул хязгаарлагдмал хийгдсэн бүсүүд бүхий тусгай зөвшөөрлийн талбайг эзэмшдэг Аниан Ресорсиз ХХК ("АР")-ийг 100% эзэмшсэн хэвээр байна.

**МОНГОЛ УЛСЫН ҮНЭТ БОЛОН СУУРЬ МЕТАЛЛЫН САЛБАРТ ХАМТРАХ НЬ**  
Хөндий Эрдсийн Дүүрэгт алт, зэс, молибденийн нөөц тодорхойлсон



Зураг 1: Эрдэнэ Ресурс-ММС стратегийн түншлэл

ММС-ийн гол хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын тэргүүлэгч групп компаниудын нэг болох М-Си-Эс Групп юм. М-Си-Эс нь өнгөрсөн 30 жилийн хугацаанд Монгол Улсад инженерчлэл, эрчим хүч, харилцаа холбоо, үл хөдлөх хөрөнгө, уул уурхай, өргөн хэрэглээний бүтээгдэхүүн, эрүүл мэнд, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж ирсэн бөгөөд нийт 10,000 гаруй ажилтантай, Монгол Улсын хамгийн том татвар төлөгчдийн нэг.

Эрдэнэ Ресурсийн хайгуул, төсөл хөгжүүлэх туршлагыг ММС-ийн олборлолт, үйлдвэрлэлийн туршлагатай нэгтгэн, түүнтэй зэрэгцэн М-Си-Эс групп компаниудын дэд бүтэц, эрчим хүчний нэмэлт шийдлүүдийг хангах чадвар нь Хөндий Эрдсийн Дүүргийг хөгжүүлэх хамгийн тохиромжтой нөхцлийг бүрдүүлж байна.

Стратегийн түншлэлийн хүрээнд Баянхөндий алтны төслийн хувьцааны хөрөнгө оруулалтыг баталгаажуулахаас гадна бүтээн байгуулалт, олборлолтын туршлага, орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүдийн хүрээнд хамтарч ажиллах боломжтой.

Өнөөг хүртэл ММС нь Баянхөндий төслийн шинэчилсэн ТЭЗҮ, бүтээн байгуулалтын бэлтгэл ажил болон Хар Морь талбайн газрын дөт гүнд өндөр агуулга бүхий бүсэд хайгуул хийх зорилгоор 10 сая ам.долларын санхүүжилтийг Эрдэнэ Монгол ХХК-д оруулсан. 3-р улиралд ТЭЗҮ-ийн шинэчлэгдсэн хувилбарыг боловсруулснаар стратегийн түншлэлийн сүүлийн үе шатыг эцэслэх бөгөөд стратегийн түншлэлийг эцэслэснээр бүтээн байгуулалтын шийдвэр гарна.

## Баянхөндий Алтны Төсөл – Өндөр агуулга бүхий төсөл хөгжүүлэлт

Баянхөндий Алтны Төслийн бүтээн байгуулалт нь компанийн богино хугацааны голлон төвлөрөх төсөл бөгөөд ойрын үед барилгын бэлтгэл ажлуудыг эхлүүлэхээр зорьж байна. Баянхөндий төсөл нь дэлхийн хэмжээнд илээр олборлох боломжтой хамгийн өндөр агуулгатай төслүүдийн нэг бөгөөд хөрөнгө оруулалтын өгөөж нь салбартаа тэргүүлэх тооцоололтой байгаа нь онцлог юм.

ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулж байгаа бөгөөд 2023 оны гуравдугаар улиралд эцэслэж танилцуулахаар төлөвлөсөн. 2020 онд ТЭЗҮ боловсруулсан зөвлөхүүдийн бүрэлдэхүүн шинэчилсэн ТЭЗҮ-ийг боловсруулах бөгөөд Баянхөндий төслийн шинэчлэгдсэн нөөц, шинээр нээн илрүүлсэн, газрын дөт гүн дэх Хар Морин Дэл талбайн нөөцийн мэдээллүүд нэмэгдэж орно. 2020 онд тайлагнасан ТЭЗҮ-тэй харьцуулахад дундаж агуулгаас гадна эхний 5 жилийн хугацаанд жилийн дундаж алтны олборлолтыг 15-25%-иар нэмэгдүүлэх боломжтой. Боловсруулах үйлдвэрийн нэвтрүүлэх чадварыг оновчлон, жилд 650000 тонн хүртэл нэмэгдүүлэх нэмэлт загварчлал болон инженерчлэлийн ажлуудыг гүйцэтгэхээс гадна анхан шатны хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардлыг шинэчлэхээр төлөвлөж байна. MMC-тэй хамтран компани нь үйлдвэрийн зарим томоохон тоног төхөөрөмж, боловсруулах үйлдвэрийн бус дэд бүтцийн бүтээгдэхүүний үнийн саналыг шинэчилсэн бөгөөд БНХАУ-ын хил нээгдсэнээс үүдэн ган, зэс, түлшний үнэ буурсан боловч макро эдийн засгийн чиг хандлагаас үүдэн захиалгын үнэ 25-50%-иар өссөн.

Эрдэнэ Ресурс нь М-Си-Эс Группийн охин компани болох М-Си-Эс Пропертис ХХК (“MCSP”)-тай гэрээ байгуулж, бүтээн байгуулалтын бэлтгэл ажлыг эхлүүлэхээр болсон. Гэрээнд төслийн талбайн дотоод болон гаднах зам, замын бэлтгэл, бутлуур, бетон зуурмагийн үйлдвэр, бүтээн байгуулалтыг дэмжих туслах барилга байгууламжууд суурилуулах ажлууд багтана. Энэхүү гэрээ нь Баянхөндий Төслийн Бүтээн байгуулалтын ерөнхий гүйцэтгэгч (“EPC”)-ын гэрээг MCSP-тэй байгуулах үндэс суурийг тавих болно.



Зураг 1: Баянхөндий бүтээн байгуулалт болон хайгуулын кэмп

Эрдэнэ Ресурс нь Баянхөндий төслийн зээлийн санхүүжилтийн хэлцлийг Канадын Экспорт Хөгжлийн Агентлаг (“EDC”) болон бусад олон улсын санхүүжүүлэгч байгууллагуудтай хийсээр байна. Зээлийн багц нь ТЭЗҮ-г шинэчлэн боловсруулж, үнэлгээ хийснээр эцэслэгдэнэ. Энэхүү зээлийн санхүүжилт болон ММС-ийн 30 сая ам.долларын хөрөнгө оруулалт нь Баянхөндий төслийг бүрэн санхүүжүүлэх тооцоололтой байна.

Өнгөрсөн жилүүдэд төслийн хувьд маш олон сорилт болон боломжууд бий болсон. 2020, 2021 онуудын цар тахлын үеэр бид төслийг илээр олборлоход бэлтгэж инженерчлэл болон тусгай зөвшөөрлүүдийн ажлыг хийж гүйцэтгэсэн. 2023 оны 3-р улиралд бүтээн байгуулалтын шийдвэрийг гаргавал 2024 оны сүүлээр төслийн олборлолтын ажлыг эхлүүлж, 2025 оны эхээр олборлолтыг эхлүүлэх төлөвтэй байна.

### **Хөндий алт - зэсийн хэтийн төлөв бүхий хэсгүүдэд нөөц нэмэгдүүлэх боломж**

Манай хайгуулын баг дэлхийн хамгийн том зах зээлээс 200 км-ийн зайд орших, томоохон алтны ордууд агуулдаг Төв Азийн Орогенийн бүсэд (“ТАОБ”) багтдаг Транс Алтайн Террейний (“ТАТ”) судлагдаагүй хэсэгт байрлах Хөндий Эрдсийн Дүүрэгт нөөцийг үргэлжлүүлэн тэлсээр байна. Төв Азийн Орогенийн Бүсийн баруун хэсэг Узбекистанд оршдог дэлхийн хамгийн том алтны орд Мурунтау, Монгол Улсын зүүн өмнөд бүс буюу Төв Азийн Орогенийн Бүсийн зүүн хэсэгт дэлхийн хамгийн том дөрвөн алт-зэсийн орд болох төлөвтэй Рио Тинтогийн Оюу Толгой орд байрлаж байна. Эрдэнэ Ресурсийн Хөндий Эрдсийн Дүүрэгт хязгаарлагдмал хайгуулын хүрээнд томоохон алт, мөнгө, хар тугалга, цайр, молибден болон зэсийн нөөцийг

илрүүлсэн. Дүүрэгт олон сая унцын нөөц бүхий алт болон бусад суурь металлын томоохон ордуудыг илрүүлэх боломжтой.

**ЗҮҮН ТӨВ АЗИЙН ОРОГЕНИЙ БҮС ДЭХ АЛТ-ЗЭСИЙН ТОМООХОН ОРДУУД**




Зураг 2: Хөндий Эрдсийн Дүүрэг болон ТАОБ дэх томоохон ордууд

Өнгөрсөн 20 жилийн хугацаанд манай техникийн баг газар нутгийн хэмжээгээрээ дэлхийд 18-д ордог Монгол Улсад 100 гаруй тусгай зөвшөөрлийн талбайд үнэлгээ, судалгаа хийсэн. Энэхүү ажилдаа хиймэл дагуулын тандалт, регионал хайгуулын хөтөлбөр болон геологийн эксперт мэргэжилтнүүдийг оролцуулж байв. Дээрх судалгаануудад тулгуурлан ТАТ нь дэлхийн томоохон алт, зэсийн ордуудын гол байршил байх магадлалтай гэж тодорхойлсон. Тухайн бүс нутагт хязгаарлагдмал хайгуул хийгдсэн, хүн амын нягтаршил багаас гадна БНХАУ-ын хил хүртэлх төмөр зам болон дэд бүтцийн бүтээн байгуулалттай ойр зэрэг давуу талуудтай.

Өнөөг хүртэл бид NI 43-101 техникийн тайлангаар баталгаажсан гурван ордыг илрүүлсэн ба цаашид хэтийн төлөв бүхий талбайд нөөцийг тооцоолохоор төлөвлөж байна. Дүүргийн хэмжээнд гүний хайгуул хязгаарлагдмал хийсэн бөгөөд цаашид илүү олон нээлт илрүүлэх боломжтой.

### ХӨНДИЙ ЭРДСИЙН ДҮҮРЭГ – НӨӨЦИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ

4 алтны нээлт, молибден зэсийн орд болон хэтийн төлөв бүхий талбайнууд



Зураг 4: ХЭД-ийн орд болон хэтийн төлөв бүхий талбай

Баянхөндий алтны орд нь илээр олборлох боломжтой, маш өндөр агуулгатай орд бөгөөд Дүүргийн хэмжээнд олборлолтыг эхлүүлэх хамгийн эхний томоохон орд юм. 3.7 г/т алтны агуулга дундаж агуулга бүхий ордын нөөц ойролцоогоор 400,000 унц тодорхойлогдсон ба уурхайн хязгаараас гадна 200,000 орчим унц алтны нөөцтэй. Алтны үнэ тогтвортой хэвээр байна гэж тооцоолбол тусгай зөвшөөрлийн талбайн баруун хязгаарт байрлах дээрх нэмэлт нөөцийг олборлон, уурхайн ашиглалтын хугацааг сунгах боломжтой.

Баянхөндийгөөс баруун зүгт 300 орчим метрийн зайд Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд алтны хүдэржилт тодорхойлогдсон. 2021 оны хагаст тус тусгай зөвшөөрлийн талбайн зүүн өмнөд хэсэгт гүйцэтгэсэн анхны өрөмдлөгийн хөтөлбөрийн хүрээнд алтны их хэмжээний хүдэржилт огтолсноор Баянхөндий ордын үргэлжлэл байх магадлалтай хэмээн тайлсан. Газрын гадаргаас 80 метрээс эхлээд 450 метр хүртэл хүдэржилт илэрсэн бөгөөд гүндээ нээлттэй хэвээр байна. 2022 онд гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөрөөр Хөндий Эрдсийн Дүүрэгт өнөөг хүртэл илрүүлсэн хамгийн зузаан хүдэржилт бүхий бүсүүдийг (UDH-21 цооногт 1.1 г/т алтны агуулга бүхий 335 метр огтолсон ба үүнд 8.7 г/т алтны агуулга бүхий 27 метр багтаасан 3.2 г/т алтны агуулга бүхий 77 метр интервал багтаж байна) огтолсон ба өндөр агуулга бүхий тэжээгч бүс (UDH-35 цооногт 13.7 г/т алтны агуулга бүхий 23 метрийн интервал огтолсон) хэмээн тайлсан бүс багтсан. Цаашид хүдэржилтийн хэмжээ, гүнийг тодорхойлоход нэмэлт өрөмдлөг шаардлагатай боловч бид илээр олборлох, цаашлаад гүний хөгжүүлэлт хийх боломжтой гэж харж байна.

2021 онд Эрдэнэ Ресурсийн хайгуулын баг газрын гадаргаас эхлэн 6 г/т алтны агуулга бүхий 45 метрийн интервал огтолсноор Хар Морь гэх хэтийн төлөв бүхий талбайг нээн илрүүлсэн. Тус нээлтийг хийснээс хойш Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд Баянхөндий ордоос хойд зүгт 2 км-т 1.5 км хүдэржилтийн трендийн дагуу өндөр агуулга бүхий алтны нээлтийг илрүүлснийг Хар Морин Дэл хэмээн нэрлэсэн. Эрдэнэ Ресурс энэхүү талбайд хэдийгээр том биш ч маш өндөр агуулга бүхий нөөцийг тодорхойлсон нь шинэчилсэн ТЭЗҮ-д багтаана.

20 км<sup>2</sup> талбайг хамарсан Хар Морь хэтийн төлөв бүхий талбайд хэд хэдэн зэрэгцээ структурын хүрээнд алт илрүүлсэн. 2023 оны хайгуулын хөтөлбөрөөр Хар Морин Дэл ордтой төстэй, газрын дөт гүнд исэлдсэн алтны хүдэржилт бүхий талбайг шалгах зорилгоор 1000 тууш метрийн 18 гүехэн цооног өрөмдөнө. Алмазан өрөмдлөгтэй зэрэгцэн, Хар Морь талбайн цөмд 9 км<sup>2</sup> талбайг хамарсан IP геофизикийн судалгааг гүйцэтгэнэ. 2023 оны 3-р улирлын дундуур энэ өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнг танилцуулах бөгөөд үргэлжлүүлэн нэмэлт өрөмдлөгийн хөтөлбөрийг гүйцэтгэнэ.

### ХӨНДИЙ ЭРДСИЙН ДҮҮРГИЙН ХАЙГУУЛ

Баянхөндийгөөс 2.4 км-т шинээр хоёр өндөр агуулга бүхий талбайг илрүүлсэн



Зураг 3: Баянхөндий орд – Улаан-Хар Морь

Хайгуулын үр дүнд тулгуурлан Баянхөндий, Улаан, Хар Морь ордууд болон холбогдох хэтийн төлөв бүхий талбай нь Хөндий-Улаан хувирлын трендийн нэг хэсэг бөгөөд олон сая унц багтаасан системийн шинжүүдийг агуулж байна хэмээн тайлсан.

Хөндий-Улаан хувирлын бүсээс баруун хойд зүгт 16 км зайд Алтан Нар төслийн талбай оршдог. Алтан Нар нь гурван томоохон хэтийн төлөв бүхий талбайгаас бүрддэг – үүнд: 6 x 1.5 км-ийн хүдэржилт бүхий алт, мөнгө, цайр, хар тугалга агуулсан томоохон Алтан Нар систем, нарийн, өндөр агуулга бүхий зэс-алтны хэтийн төлөв бүхий Номин Тал талбай, зэсийн порфирийн хэтийн төлөв бүхий хайгуул хязгаарлагдмал хийгдсэн Оюут Хөндий талбай багтдаг.

Алтан Нар нь Хөндий Эрдсийн Дүүрэгт Эрдэнэ Ресурсийн илрүүлсэн анхны алтны нээлт бөгөөд 2015 онд тус төслийн анхны нөөцийн тооцооллыг танилцуулсан. 2016 онд Баянхөндийг нээн илрүүлснээс хойш Алтан Нар төсөлд хайгуул хязгаарлагдмал



хийгдсэн. Гэсэн хэдий ч Алтан Нарын алттай дүйцэх агуулга нь 2.5 г/т-с дээш, алттай дүйцэх бодитой нөөц 450,000 унц, алттай дүйцэх боломжит нөөц 277,000 унц тодорхойлсон. Металлургийн туршилтаар Алтан Нарын нөөцийн тодорхой хэсгийг Баянхөндийд төлөвлөж буй боловсруулах үйлдвэрт (CIP) боловсруулах боломжтойг тодорхойлсон. Баянхөндий төслийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэснээр Алтан Нарын хайгуулын хөтөлбөрийг эрчимжүүлэхээр төлөвлөж байна.

Тусгай зөвшөөрлийн талбайд илрүүлсэн ордууд болон хэтийн төлөв бүхий талбайгаас гадна бид дүүргийн хэмжээнд хөрөнгө оруулалт хийх эсвэл түншлэх замаар нөөцийг нэмэгдүүлэх боломжтой. Монгол Улсын баруун өмнөд хэсэгт урт хугацааны турш үйл ажиллагаа эрхэлж буй туршлагатай компанийн хувьд MMC-тэй хамтран ажилласнаар энэхүү өндөр хэтийн төлөв бүхий бүс нутагт тусгай зөвшөөрлийн хэмжээг тэлэх боломжтой.

### Зуун Мод молибден-зэсийн порфирийн цогцолбор

MMC-тэй хамтран хөгжүүлэх алтны төслүүдээс гадна Эрдэнэ Ресурс нь Ази тивд хөгжүүлэлт хийгдээгүй хамгийн том зэс-молибденийн төслүүдийн нэг болох Зуун Мод төслийг 100 хувь эзэмшдэг. 2005 онд Эрдэнэ Ресурс нь хайгуулын эхний үе шатанд буй Зуун Мод хэтийн төлөв бүхий талбайг худалдаж авсан бөгөөд 2011 онд Оюутолгой ил уурхайн олборлолт эхэлсэн жил бид 16 км диаметр бүхий порфирийн цогцолборт зэс-молибденийн хэтийн төлөв бүхий талбайнууд илрүүлснээс гадна томоохон молибден-зэсийн нөөцийг тооцоолсон.

БНХАУ-ын зэвэрдэггүй ган үйлдвэрлэгчдийн эрэлт ихсэж, Латин Америкийн олборлогчдын нийлүүлэлт тасалдсан зэргээс үүссэн хомсдол нь 2023 онд молибденийн үнэ өсөх хүчин зүйл байв. Үр дүнд 2017 онд \$7.25/фунт, 2022 онд \$20/фунт байсан молибденийн оксидын үнэ энэ оны эхээр фунт тутамд 45 ам.доллар болж өссөн. Одоогоор фунт тутамд 25 ам.доллар байгаа нь Зуун Мод төслийг эдийн засгийн өндөр ач холбогдолтой болгож байна.

4 болон 5-р сард Компани нь өнөөгийн тодорхойлсон баттай болон боломжит нөөцийн захаар 4000 метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг гүйцэтгэсэн бөгөөд өргөн хэмжээний өрөмдлөгийн хөтөлбөрийн дүнд нөөцийг нэмэгдүүлэх боломжтой. Тус өрөмдлөгөөр молибдений өндөр агуулгатай бүсийн үргэлжлэлийг шалгасан ба өнөөгийн тодорхойлсон ордын баруун болон хойд хэсэгт шинэ хэтийн төлөв бүхий талбайд хайгуул хийсэн. Ирэх долоо хоногуудад үр дүнг танилцуулна.

Эрдэнэ Ресурс нь 2021 оны сүүлээр RPMGlobal-ын гүйцэтгэсэн төслийн урьдчилсан үнэлгээнд тулгуурлан ирэх саруудад зах зээл, техник, эдийн засгийн судалгаа болон тусгай зөвшөөрлүүд авах ажлыг хийж гүйцэтгэнэ. Компани дээрх судалгаа, хайгуулын хөтөлбөрийн үр дүнд үндэслэн ойрын хугацаанд Зуун Модын техникийн тайланг шинэчлэн боловсруулахаар төлөвлөж байна.

БНХАУ-ын хилээс 200 км-ийн зайд оршдог Ази тивд хөгжүүлэлт хийгдээгүй хамгийн том молибден-зэсийн ордуудын нэг тул компанийн удирдлагууд Зуун Мод төсөл нь ирээдүйд уурхай болох нь гарцаагүй гэж үзэж байна. Молибденийн зах зээлд нийлүүлэлт хомсдож, зэсийн эрэлт өндөр байгаа энэ үед Зуун Мод төслийг Баянхөндий алтны төслийн хамт зэрэгцэн хөгжүүлэх хамгийн тохиромжтой. 2022 оны сүүлээр Зижин компани БНХАУ-ын молибденийн төслийг 5.91 тэрбум юанаар (815 сая ам.доллар) худалдан авсан нь бат бэх, зэвэрдэггүй ган үйлдвэрлэхэд голчлон ашигладаг энэхүү чухал металлын нийлүүлэлт чухал ач холбогдолтойг харуулж байна. Мөн тусгай зөвшөөрлийн талбай нь томоохон хэмжээний зэсийн хүдэржилтийг агуулах боломжтой нь ногоон шилжилтийг дэмжих эрэлтийг хангах боломжтой.



Зураг 6: Зуун Мод молибденийн хүдэржилт

## Хүний нөөц –Монгол удирдлага бүхий баг хамт олон

Эрдэнэ Ресурсийн амжилт нь баг хамт олны хүчин чармайлттай шууд хамааралтай. Би бүх салбарт ажилласан туршлагатай удирдлагын баг, геологи, инженер, санхүү, захиргаа болон олон нийттэй харилцах чиглэлээр ажилладаг 50 гаруй монгол мэргэжилтнүүдээс бүрдсэн баг хамт олноороо бахархдаг.

ММС-тэй хийсэн түншлэл болон Баянхөндийн алтны төслийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлын хүрээнд Монгол дахь охин компани Эрдэнэ Монгол ХХК (“ЭМ”)–ийн удирдлагын багийг бүрдүүлж байна. Стратегийн түншлэлийн нөхцөлийн дагуу бид Эрдэнэ Монгол ХХК-ийн Гүйцэтгэх захирал, Хөгжил хариуцсан захирлуудыг томилох бөгөөд эдгээр албан тушаалд А.Билгүүн, Жон Лёнс нарыг тус тус томилсон. Томилогдсон захирлууд хоёулаа Эрдэнэ Ресурс компанид 10 гаруй жил ажилласан бөгөөд байгууллагын соёл болон Баянхөндий алтны төслийн талаар нарийн мэдлэгтэй, туршлагатай албан тушаалтнууд юм. 2024 оны дундуур Баянхөндийн бүтээн байгуулалтын оргил үед 500 гаруй ажилтантай болох төлөвлөгөөтэй байгаа бөгөөд дийлэнх нь Монгол ажилтнуудаас бүрдэнэ. Олборлолтыг эхлүүлснээр 450 орчим шууд ажлын байр бий болно. Бид ихэвчлэн орон нутгийн иргэдээс хүний нөөцөө бүрдүүлэхээр төлөвлөсөн ба эхний 20 иргэдийг Баянхөндий төслийн хүний нөөцийг бэлтгэх зорилгоор Өмнөговь аймаг дахь ММС-ийн уурхайд хүнд машин механизмын операторын сургалтад хамруулж байна.

Бид Баянхөндий төслийн талбайтай ойр байрлах орон нутгийн иргэдтэй нягт хамтран ажиллаж, оршин суугчдад үр өгөөжөө өгөх төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Төслийн талбай нь хамгийн ойр төв суурин болох Шинэжинст сумаас 80 орчим км зайд оршдог, мөн төлөвлөсөн уурхайгаас 10 км-т байнгын оршин суугч байхгүй боловч бид Баянхонгорын иргэдтэй идэвхтэй хамтран ажилласаар байна. Энэ оны эхээр би ММС-ийн Гүйцэтгэх захирал, доктор Г.Батцэнгэлийн хамтаар Баянхонгор аймагт компанийн төлөөлөгчийн газраа нээсэн. Энэ үеэр бид Шинэжинст суманд нээлттэй өдөрлөг зохион байгуулж, иргэдтэй зөвлөлдөх хэлэлцүүлэг өрнүүлсэн. Бид Шинэжинст суманд чанарын шаардлага хангасан ундны усны хангамжийг бий болгохоор ажиллаж байгаагаас гадна цэцэрлэг, сургуулийн ариун цэврийн байгууламжуудыг засварлах ажлыг эхлүүлээд байна. Түүнээс гадна, бид байгаль орчныг хамгаалах чиглэлээр ажилладаг 15 байгаль хамгаалагчийг Канад улсад туршлага судлуулах боломжийг эрэлхийлж эхлээд байна.

Бид ил тод байдал, үр өгөөжийг хуваалцах замаар Монгол Улсын хөгжилд хувь нэмрээ оруулахаар зорьж байна. Хамгийн урт хугацаанд үйл ажиллагаа эрхэлж буй гадаадын хөрөнгө оруулалттай уул уурхайн компанийн хувьд Монгол Улсыг түүх, соёлоо хадгалахын зэрэгцээ чөлөөт зах зээлийн эдийн засагт эрч хүчтэй шилжсэн шилжилт, дэлхийн хамгийн том ашигт малтмалын ордуудын нэг болох Оюу Толгойн зэс-алтны далд уурхайн бүтээн байгуулалт ашиглалтад орж буйн гэрч болсон нь

орчин үеийн уул уурхай Монголын баялаг түүх, соёлтой хэрхэн зэрэгцэн оршиж болдгийг ойлгууллаа.



Зураг 4: Эрдэнэ Ресурс-ММС Нээлттэй өдөрлөг, Шинэжинст сум

### Санхүүгийн чадавхи – Урт хугацаанд дэмжиж ирсэн хөрөнгө оруулагчид

Эрдэнэ Ресурсийн хамгийн том давуу талуудын нэг бол урт хугацаанд тогтвортой дэмжиж ирсэн хувьцаа эзэмшигчид юм. Нийт хувьцааны 2/3-ийг үнэ цэнийг бий болгох компанийн стратегийг дэмждэг урт хугацааны хөрөнгө оруулагчид эзэмшдэг.

Компанийг 2002 онд үүсгэн байгуулснаас хойш компанийн төв оффис байрладаг Канадын зүүн бүсийн хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын дийлэнх хэсгийг бүрдүүлсэн нь алтны уурхайг олборлолт руу ахиулах түвшинд хүрэх боломжийг олгосон. Манай хөрөнгө оруулагчдын 1/3 нь Канадын Атлантын бүсээс гаралтай. Түүнээс гадна компанийн удирдлага, ТУЗ-ийн гишүүд, ажилтнуудын олонх нь энэ бүсээс гаралтай бөгөөд Компанийн хувьцааны 10%-ийг эзэмшдэг.

2020 оны дундуур бид хөрөнгө оруулагчдын эгнээнд Эрик Спроттыг угаж авсан бөгөөд тэрээр хэд хэдэн удаагийн хөрөнгө оруулалтаар Эрдэнэ Ресурсийн 18%-г эзэмшиж байна.

Одоогоос таван жилийн өмнө бид Монголын болон Торонтогийн хөрөнгийн бирж дээр давхар бүртгүүлсэн анхны бөгөөд одоогоор цорын компани болсон. Өнөөдөр бид орон нутгийн олон мянган иргэдийг багтаасан Монголын 6000 гаруй хувьцаа эзэмшигчтэй болсон.

Баянхөндий алтны төсөл нь 2025 оноос эхлэн их хэмжээний мөнгөн урсгал бий болгоно гэж төсөөлж байгаа тул бид ойрын ирээдүйд хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ төслүүдээ үргэлжлүүлэн хөгжүүлэхээр ажиллаж байна.

### Дүгнэлт


Өнгөрсөн жил манай компанийн хувьд томоохон өөрчлөлт, шинэчлэлтийн жил болж өнгөрлөө. ММС-тэй хийсэн стратегийн түншлэлийн хүрээнд Баянхөндий алтны төслийг 18 сарын хугацаанд хөгжүүлж, 2025 оны эхээр анхны алтаа олборлохоор төлөвлөж байна.

Баянхөндий төслийг олборлолт руу хөгжүүлэхийн зэрэгцээ бид Хөндий Эрдсийн Дүүргийн нөөцийг нэмэгдүүлэх боломжуудыг эрэлхийлсээр байх болно. Бид эдийн засгийн ашигтай нөөцийг тооцоолох хэд хэдэн хэтийн төлөв бүхий талбайгаас гадна өнөөгийн нөөцийг нэмэгдүүлэх өрөмдлөгийн талбайг тодорхойлоод байна. ММС-тэй хийсэн түншлэлийн хүрээнд 700 км<sup>2</sup> талбайг хамарсан бүс нутагт хөрөнгө оруулалт хийх боломжтой боллоо. Бидний хайгуулын амжилтуудаас харахад, Хөндий-Улаан тренд, Хөндий Эрдсийн Дүүрэг нь дэлхийн жишигт нийцсэн үнэт болон суурь металлын эрдсийн дүүрэг болох нь гарцаагүй.

Мөн Зуун Мод молибден-зэсийн төсөл нь ихээхэн үнэ цэнийг бий болгоно хэмээн харж түүнийг нэмэгдүүлэх боломжуудыг үргэлжлүүлэн судалж байна.

Эцэст нь шаргуу хөдөлмөрлөж буй баг хамт олон, үргэлж дэмждэг хувьцаа эзэмшигчдэдээ талархал илэрхийлмээр байна. Ирэх онд бид илүү амжилтыг хүлээж байна.

Хүндэтгэсэн,



Петер К. Акерли  
Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал  
2023 оын 6 сар

<sup>1</sup> Батлагдсан & Магадалсан: 4.4. г/т алтны агуулга бүхий 165,000 унц батлагдсан, 3.4 г/т алтны агуулга бүхий 256,000 унц магадалсан үйлдвэрлэлийн нөөц; Үйлдвэрлэлийн нөөцийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Хөндий Алтны Төсөл NI 43-101 Техникийн Тайлан, Tetra Tech 2019 оны 12 сарын 4-нд SEDAR болон компанийн вебсайт дээрх мэдээлэлтэй танилцана уу.

ii Баянхөндий алтны төслийн эрдсийн нөөцийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй 2021 оны 8 сарын 16-нд танилцуулсан 2021 оны 2-р улирлын санхүү болон үйл ажиллагааны тайлангийн хэвлэлийн мэдээнээс танилцана уу.

iii Алтан Нар эрдсийн нөөцийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй 2020 оны 3 сарын 29-нд танилцуулсан "Алтан Нар алт, полиметаллын төслийн NI 43-101 техникийн тайлан" болон 2021 оны 3 сарын 29-нд Майкл МадДолан (P. Geo N.S) Жерми Кларк (AusAIG, RPM Global), Анрю Келли (P. Eng Blue Coast Research Ltd) боловсруулсан Алтан Нар техникийн тайлантай SEDAR болон компанийн вебсайтаас танилцана уу.